



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 06 өдөр

Дугаар

1/117

Номгон

Заг сумын хүүхдийн цэцэрлэгийн ариун
цэврийн байгууламжийн хэвийн ажиллагааг
хангахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын Ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.8, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.2, 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Заг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн кампресорийг шинэчлэн засварлахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Ариун цэврийн байгууламжийн кампресорийг шинэчлэн засварлахад шаардлагатай 2.590.000 (Хоёр сая таван зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (В.Наранчимэг)-д, ариун цэврийн байгууламжийг засварлан үйл ажиллагааг хэвийн болгож тайлан мэдээг Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэхийг Заг сумын цэцэрлэгийн эрхлэгчид даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

• 625010355